

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3.Аудитын тайлан	12
3.1. Ерөнхий зүйл	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал.....	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.9. Аудитын илрүүлэлт	16
Залруулсан алдаа.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	16
Аудитын зөвлөмж	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	17
4. Менежментийн захидал.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТХН	Төсөл Хэрэгжүүлэгч Нэгж



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ
УЛААНБААТАР ХОТЫН ЦЭВЭР
АГААР” ТӨСЛИЙН НЭМЭЛТ
САНХҮҮЖИЛТИЙН ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Н.БАЯРТОГТОХ
ТАНАА

2021.02.25 № 07/602
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн нэмэлт санхүүжилтийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

“Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн нэмэлт санхүүжилтийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн, үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг, хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын тайлант оны төлөвлөгөөнд 3 хөтөлбөрийн хүрээнд 8 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 87.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу, үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	4,283,084,339.54
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	4,273,057,066.54
31100	Кассад байгаа бэлэн мөнгө	0.00	2.80
31140	Касс арилжааны банк	0.00	2.80
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	0.00	4,273,057,063.74
31210	Төгрөг	0.00	3,665,018,988.60
31211	Төрийн сангийн харилцах	0.00	3,658,512,428.60
31213	Арилжааны банк дахь харилцах	0.00	6,506,560.00
31220	Гадаад валют	0.00	608,038,075.14
31223	Арилжааны банк дахь харилцах	0.00	608,038,075.14
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	10,027,273.00
35400	Хангамжийн материал	0.00	10,027,273.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	10,027,273.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	44,574,665.18
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	44,574,665.18
39200	Биет хөрөнгө	0.00	44,574,665.18
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.00	97,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(75,155,068.49)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	0.00	17,862,393.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(1,420,121.65)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0.00	32,950,719.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(26,663,257.60)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	4,327,659,004.72
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	6,500,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	6,500,000.00
41400	Урьдчилж орсон орлого	0.00	6,500,000.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	0.00	6,500,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	4,321,159,004.72
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	4,321,159,004.72
51200	Хуримтлагдсан үр дүн	0.00	4,321,159,004.72
51210	Өмнөх үеийн үр дүн	0.00	36,460,077.70
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	4,284,698,927.02
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.00	4,327,659,004.72

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	5,666,974,697.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	5,666,974,697.82
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	5,666,974,697.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	5,598,887,697.82
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	2,766,653.82
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	121,044.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.00	5,596,000,000.00
120009	Бусад орлого		68,087,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.00	583,168,112.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	583,168,112.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	583,168,112.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	229,414,852.00
210101	Үндсэн цалин	0.00	229,414,852.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	59,099,981.40
210201	Тэтгэврийн даатгал	0.00	43,195,781.40
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	5,301,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	4,241,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	1,060,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	5,301,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	25,921,956.00
210304	Байрны түрээс	0.00	25,921,956.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	33,044,236.00
210401	Бичиг хэрэг	0.00	2,803,687.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	7,912,555.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	14,443,892.00
210404	Ном, хэвлэл	0.00	5,496,078.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	2,388,024.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	16,231,413.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	16,231,413.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	141,620,869.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	141,426,435.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	73,390.00
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	0.00	121,044.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	77,834,805.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	68,087,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0.00	9,747,805.52
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	0.00	5,083,806,584.90

IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	799,107,657.88
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	0.00	(10,786,374.12)
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалтай хөрөнгийн зардал	0.00	809,894,032.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	0.00	4,284,698,927.02
VI-I	Засгийн газрын хувь оролцоо	0.00	0.00
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	0.00	0.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	5,673,474,697.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	5,673,474,697.82
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	5,673,474,697.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	5,598,887,697.82
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	2,766,653.82
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	121,044.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.00	5,596,000,000.00
120009	Бусад орлого	0.00	74,587,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	583,447,580.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	583,447,580.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	583,447,580.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	229,414,852.00
210101	Үндсэн цалин	0.00	229,414,852.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	59,099,981.40
210201	Тэтгэврийн даатгал	0.00	43,195,781.40
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	5,301,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	4,241,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	1,060,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	5,301,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	25,921,956.00
210304	Байрны түрээс	0.00	25,921,956.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	33,044,236.00
210401	Бичиг хэрэг	0.00	2,803,687.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	7,912,555.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	14,443,892.00
210404	Ном, хэвлэл	0.00	5,496,078.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	2,388,024.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	26,258,686.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	26,258,686.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	141,499,825.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	141,426,435.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	73,390.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	68,087,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	68,087,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	121,044.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	121,044.00

213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	121,044.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	5,090,027,117.42
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	827,756,425.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	827,756,425.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	827,756,425.00
220001	Барилга байгууламж	0.00	809,894,032.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	17,862,393.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-827,756,425.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	10,786,374.12
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.00	(10,786,374.12)
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	0.00	(10,786,374.12)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	4,273,057,066.54
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	4,273,057,066.54

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн бууралт	0.00	0.00	0.00	0.00
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	36,460,077.70	0.00	0.00	36,460,077.70
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	36,460,077.70	0.00	0.00	36,460,077.70
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	4,284,698,927.02	4,284,698,927.02
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн бууралт	0.00	0.00	0.00	0.00
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	36,460,077.70	0.00	4,284,698,927.02	4,321,159,004.72

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,366,955,800.00	1,342,922,571.40	1,024,033,228.60	56.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	716,869,100.00	533,028,539.40	183,840,560.60	74.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	716,869,100.00	533,028,539.40	183,840,560.60	74.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	244,900,400.00	229,414,852.00	15,485,548.00	93.7
210101	Үндсэн цалин	244,900,400.00	229,414,852.00	15,485,548.00	93.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,267,800.00	59,099,981.40	7,167,818.60	89.2
210201	Тэтгэврийн даатгал	50,363,600.00	43,195,781.40	7,167,818.60	85.8
210202	Тэтгэмжийн даатгал	5,301,400.00	5,301,400.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,241,100.00	4,241,100.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,060,300.00	1,060,300.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,301,400.00	5,301,400.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,267,000.00	25,921,956.00	12,345,044.00	67.7
210304	Байрны түрээс	38,267,000.00	25,921,956.00	12,345,044.00	67.7
2104	Хангамж, бараа материалын зардал	36,659,700.00	33,044,236.00	3,615,464.00	90.1
210401	Бичиг хэрэг	2,833,700.00	2,803,687.00	30,013.00	98.9
210402	Тээвэр, шатахуун	8,605,900.00	7,912,555.00	693,345.00	91.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,279,100.00	14,443,892.00	2,835,208.00	83.6
210404	Ном, хэвлэл	5,546,100.00	5,496,078.00	50,022.00	99.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,394,900.00	2,388,024.00	6,876.00	99.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,121,100.00	44,121,079.00	21.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	44,121,100.00	44,121,079.00	21.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	286,653,100.00	141,426,435.00	145,226,665.00	49.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	286,653,100.00	141,426,435.00	145,226,665.00	49.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,650,086,700.00	809,894,032.00	840,192,668.00	49.1
220001	Барилга байгууламж	1,150,086,700.00	809,894,032.00	340,192,668.00	70.4
222002	Тоног төхөөрөмж	500,000,000.00	0.00	500,000,000.00	0.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,366,955,800.00	5,596,000,000.00	-	236.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,366,955,800.00	5,596,000,000.00	-	236.5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	0.00	-	-
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	0.00	-	-
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	2,366,955,800.00	5,596,000,000.00	-	236.4
				3,229,044,200.00	

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	4,255,268,063.54	- 4,255,268,063.54	-
	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
	АЖИЛЛАГСДЫН ТОО	11	11	0	100.0
	Удирдах ажилтан	1	1	0	100.0
	Гүйцэтгэх ажилтан	8	8	0	100.0
	Үйлчлэх ажилтан	2	2	0	100.0

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн нэмэлт санхүүжилтийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төслийн зохицуулагч Н.Баяртогтох танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийг дахин үнэлж бүртгэх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөх, санхүүгийн программыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар “Интер Аудит” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр, ахлах аудитор С.Уртнасан, аудитор Б.Гомбо, чанарын хяналтын менежер П.Дарамрагчаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн нэмэлт санхүүжилтийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 8 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

“Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн нэмэлт санхүүжилтийн зорилго нь гэр хорооллын хэрэглэгчдийг утаа бага ялгаруулдаг халаалтын хэрэгслүүдээр хангах, цаашид хөгжлийн түншүүдтэй хамтран Улаанбаатар хотын утааг бууруулах дунд хугацааны тодорхой арга хэмжээ боловсруулах юм. Төсөл нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдтэй. Үүнд:

- Гэр хорооллын нарийн тоосонцрыг бууруулах;
- Улаанбаатар хотын төвийн хэсгийн нарийн тоосонцрыг бууруулах;
- Төслийн менежмент ба мониторинг, хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэх;
- Гэр хорооллын сонгогдсон байршил дахь айл өрхийг цахилгаанаар халдаг төхөөрөмжөөр хангах.

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 8 арга хэмжээнээс 1 арга хэмжээ гэрээ байгуулагдаагүй бол 2 арга хэмжээний төлөвлөгөөт хугацаа Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас сунгагдсан байна. Эдгээр арга хэмжээнүүдийг задалж харуулбал:

№	Арга хэмжээний зорилго	Төрөл	Биелэлт
1	ТХН-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, бие даасан зөвлөхтэй гэрээ байгуулж хамтран ажиллах	Зөвлөх үйлчилгээ	2020 оны 05 дугаар сарын 26-нд зөвлөхтэй гэрээ байгуулан ажиллаж байна
2	Шөнийн дулаан хуримтлуурт цахилгаан халаагуур хөтөлбөрийн хүрээнд Техникийн бичиг баримт боловсруулах	Зөвлөх үйлчилгээ	2020 оны 07 дугаар сарын 1-нд гэрээ байгуулж хуримтлуурт халаагуурын техникийн баримт бичиг боловсруулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэн хамтран ажиллаж байна
3	Шөнийн дулаан хуримтлуурт цахилгаан халаагуур хөтөлбөрийн хүрээнд Хяналт, үнэлгээ, борлуулалт хийх	Зөвлөх үйлчилгээ	2020 оны 08 дугаар сарын 31-нд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажиллаж байна

4	Шөнийн дулаан хуримтлуурт цахилгаан халаагуур хөтөлбөрийн хүрээнд Олон нийттэй харилцах, мэдээлэл сурталчилгаа хийх	Зөвлөх үйлчилгээ	2020 оны 09 дүгээр сарын 25-нд гэрээ байгуулан гүйцэтгэгчтэй хамтран ажиллаж байна
5	Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах Монгол Улсын Засгийн газар, Нийслэлийн засаг даргын мөрийн хөтөлбөрийн хүрээнд Нийслэл, улсын өмчийн халаалтын зуухнуудыг буулгаж, төвлөрсөн дулааны системд холбох ажлын хүрээнд Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн халаалтын зуухыг буулган төвийн дулаанд холбох	Ажил	2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр гэрээ байгуулан 303 дугаар ангийн халаалтын зуухыг буулгаж, төвлөрсөн дулаан хангамжийн систем холбох ажлыг дуусган 2020 оны 12 дугаар сарын 8-нд Улсын комисст хүлээлгэж өгсөн байна
6	2 тарифт тоолуур, автомат ханган нийлүүлж, суурилуулах	Ажил	Гүйцэтгэгчээр Улаанбаатар хотын цахилгаан түгээх сүлжээ Төрийн өмчит хувьцаат компани шалгарсан боловч Монгол Улсын Засгийн газраас гаргасан цахилгаан, дулааны үнийг тэглэсэнтэй холбоотойгоор тус компанийн 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 2/2441 тоот бичгээр уг ажил хойшлогдсон.
7	Шөнийн дулаан хуримтлуурт цахилгаан халаагуур нийлүүлэх, суурилуулах, борлуулалтын дараах үйлчилгээ үзүүлэх	Бараа	2020 оны 10 дугаар сарын 22-нд бараа нийлүүлж суурилуулах гэрээ байгуулсан боловч Ковид-19 цар тахлын улмаас нийлүүлэлт хойшилсон.
8	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт агаар орчны бохирдлыг хэмжих хяналтын тоног төхөөрөмж бэлтгэн нийлүүлэх	Бараа	2020 оны 10 дугаар сарын 22-нд гэрээ байгуулсан боловч Ковид-19 цар тахлын улмаас барааны нийлүүлэлт 45 хоногоор хойшилсон.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах арга хэмжээний тухай” 114 дүгээр тогтоол.
- Улсын Их Хурлын 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталсан “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

“Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн нэмэлт санхүүжилт нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаандаа Дэлхийн банкны Санхүүгийн гарын авлага, Сангийн сайдын 2007 оны 326-р тушаалаар батлагдсан журамд заасан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэн гаргадаг байна. Дэлхийн банкны санхүүгийн тайлангийн гарын авлагад Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журмын өөрчлөлтийг тусгаагүй байна.

Тайлант онд Нийслэлийн дотоод аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2019 оны тайлант хугацааг хамруулан нийцлийн аудит хийсэн байна. Аудитаар цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын

мөнгөн гүйлгээтэй холбоотой 341,918.9 мянган төгрөгийн зөрүүтэй мэдээллийг залруулж, нийт 26 мэдээллийг хугацаа хоцроосон, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ болох 17,222.4 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй зөрчлүүдийг илрүүлсэн байна.

“Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн нэмэлт санхүүжилтийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,324,222.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 26,484.4 мянган төгрөгөөр тооцсон. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дэлхийн банкны санхүүжилтээр 2012-2019 онуудад 15 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр Улаанбаатар хотын цэвэр агаар төсөл хэрэгжсэн байна. Засгийн газар Дэлхийн Банктай 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдөр “Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн нэмэлт санхүүжилтийн хэлэлцээрийг байгуулж, Улсын Их Хурал 2020 онд 12 сая ам.долларын өртөгтэй тус төслийн нэмэлт санхүүжилтийн хэлэлцээрийг соёрхон баталсан. Төсөл нь тайлант хугацаанд 2 сая ам.долларын санхүүжилтийг авсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	4,273,057.1	4,273,057.1
Бараа материал	0.0	10,027.2	10,027.2
Үндсэн хөрөнгө	0.0	44,574.7	44,574.7
Нийт хөрөнгө	0.0	4,327,659.0	4,327,659.0
Өр төлбөр	0.0	6,500.0	6,500.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	0.0	4,321,159.0	4,321,159.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	0.0	4,327,659.0	4,327,659.0

Тайлант онд мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 4,273,057.1 мянган төгрөг байгаа нь тайлант онд хоёр сая доллар буюу 5,596,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 1 арга хэмжээний гэрээ байгуулагдаагүй, 2 арга хэмжээний хугацаа сунгагдсанаар төлөвлөсөн зардлууд гараагүйгээс шалтгаалсан байна.

Энэ нь төслийн хугацаа сунгагдаж, үйл ажиллагааны тогтмол зардлыг өсгөх сөрөг нөлөөтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 10,027.2 мянган төгрөг болж өссөн нь “Дулаалга аян-3”-ын хүрээнд гэр хорооллын айл өрхийн гэрийг дулаалгын материал ашиглан дулаан алдагдлыг хэрхэн бууруулсан, шөнийн дулаан хуримтлуур цахилгаан халаагуураар

түлшний хэрэглээг хэрхэн бууруулж байгааг сурталчилж, иргэдэд таниулан мэдүүлэх зорилгоор 2 ширхэг гэрийг иж бүрэн дулаалгийн хамт худалдан авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 44,574.7 мянган төгрөг байгаа нь Засгийн газрын зүгээс 36,460.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлж, 17,862.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авч, тайлант хугацаанд 9,747.8 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг байгуулсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 6,500.0 мянган төгрөг болж өссөн нь шөнийн дулаан хуримтлуурт цахилгаан халаагуурыг иргэдэд хөнгөлөлттэй нөхцлөөр нийлүүлэхээр 16 иргэнтэй гэрээ байгуулж төлбөрийг хүлээн авсан боловч Ковид-19 цар тахлын улмаас цахилгаан халаагуурыг айл өрхүүдэд суурилуулж, хүлээлгэн өгч чадаагүйн улмаас шалтгаалжээ. Энэ нь дараагийн тайлант үед айл өрхүүдэд цахилгаан халаагуурыг суурилуулснаар орлого гэж хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд орлогын эх үүсвэр болох үр нөлөөтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,321,159.0 мянган төгрөг байгаа нь тайлант онд 5,666,974.7 мянган төгрөгийн орлого олж, 1,382,275.8 мянган төгрөгийн зардал гаргаж, 36,460.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг ТХН-д шилжүүлснээс шалтгаалжээ.

“Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн арилжааны банканд хуримтлагдсан хүүгийн орлого болох 68,087.0 мянган төгрөгийг Сангийн Яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А46 тоот тушаалаар тайлант оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны зардалд зарцуулах эрхийг олгосон. Уг санхүүжилт нь ТХН-ийн төсийн төсөлд тусгагдаагүй нэмэлт орлого тул “үйл ажиллагааны бусад орлого”-оор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг 2,366,955.8 мянган төгрөгөөр, санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,366,955.8 мянган төгрөгөөр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж батлуулсан байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,366,955.8 мянган төгрөгийг төсөвлөснөөс 2,366,955.8 мянган төгрөгийг гадаадын эх үүсвэрээс 100.0 хувь санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр гадаадын эх үүсвэрээс 5,596,000.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 533,028.5 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 809,894.0 мянган төгрөг, нийт 1,342,922.6 мянган төгрөгийг зарцуулсан байна. Хөрөнгийн зардалд 809,894.0 мянган төгрөг зарцуулсан нь Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн халаалтын зуухыг буулган төвлөрсөн дулааны системд холбох ажилд 794,252.8 мянган төгрөг, айл өрийн дулаалгын төлбөрт 15,641.2 мянган төгрөг тус тус зарцуулсантай холбоотой байна.

Төсвийн нийт зарлагын гүйцэтгэл 1,342,922.6 мянган төгрөг буюу 56.7 хувьтай байгаа нь төлөвлөгөөнд тусгагдсан 8 арга хэмжээнээс 1 арга хэмжээний гэрээ байгуулагдаагүй, 2 арга хэмжээний хугацаа Ковид-19 цар тахлын улмаас хойшлогдож, бараа, ажил үйлчилгээний зардлыг 183,840.6 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 840,192.7 мянган төгрөгөөр, нийт 1,024,033.3 мянган төгрөгийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

ТХН нь Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны цахим хуудсанд 146 мэдээллийг байршуулахаас 128 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан бөгөөд 2 мэдээлэл нь оруулах хугацаандаа байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

“Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн хэрэгжүүлэгч нэгж нь “Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн нэмэлт санхүүжилтийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 17,892.3 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илрүүлснээс 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. “Дулаалга аян-3”-ын хүрээнд сурталчилгааны зорилгоор авсан 10,027.2 мянган төгрөгийн 2 ширхэг гэрийг бүртгэлд тусгаагүй байсныг бараа материалын дансанд бүртгэсэн.
2. “Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн 68,087.0 мянган төгрөгийн хүүгийн орлогыг 2020 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагаандаа ашиглах эрхийг Монгол Улсын Сангийн Яамны Төрийн нарийн бичгийн А46 тоот тушаалаар олгосон. Уг орлого болон түүний зарцуулалтыг бүртгэлд тусгаагүй байсныг орлого, зардлаар бүртгэж залруулсан.
3. Шөнийн дулаан хуримтлуурт цахилгаан халаагуурыг иргэдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр нийлүүлэхээр 16 иргэнээс 6,500.0 мянган төгрөгийн урьдчилгаа хүлээн авсан боловч боловч санхүүгийн тайланд тусгаагүй байсныг мөнгөн хөрөнгө болон урьдчилж олсон орлогоор хүлээн зөвшөөрч санхүүгийн байдлын тайланд бүртгэсэн.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 17,892.3 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илрүүлснээс 1 зөрчилд албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 146 мэдээллээс 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл “Шилэн дансны зарчим”-ын 4.1 “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” дэх хэсгийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын зөвлөмж

Аудитаар нийт 17,892.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

“Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн нэмэлт санхүүжилтийн хувьд дараагийн аудитаар дараах асуудлуудыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Тайлант онд шөнийн дулаан хуримтлуурт цахилгаан халаагуурыг иргэдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр нийлүүлэх ажлыг хийж эхэлсэн бөгөөд гэрээний дагуу худалдан авагч нь ТХН-д төлбөрийг 30 сарын хугацаанд тэнцүү дүнгээр хуваан төлөх нөхцөлтэй. Уг төсөл нь 2021 оны 12 дугаар сарын 31-нд дуусах тул дээрх цахилгаан халаагуурын борлуулалтын орлогыг төсөл дууссанаас хойших хугацаанд хэрхэн бүртгэж толилуулахыг Дэлхийн Банк болон холбогдох дээд шатны эрх бүхий байгууллагаас тодруулах.
- Төслийн Санхүүжилтийн хэлэлцээрт тусгасан нийт зээлийн дүн 12 сая ам.доллар бөгөөд тайлант онд 2 сая ам.долларын санхүүжилтийг авсан. Ковид-19 цар тахалтай холбогдуулан гаргасан Монгол Улсын Засгийн газрын шийдвэрүүд нь ТХН-ийн тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 1 арга хэмжээ дараа он руу хойшлуулахад нөлөөлсөн байна. Иймээс, Төслийн гүйцэтгэл Санхүүжилтийн гэрээнд тусгасан 2021 оны 12 дугаар сарын 31-нд дуусах эсэхийг анхаарах.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: ТХН нь өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон, хууль тогтоомж, дүрэм журам, олон улсын стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”, мөн тус хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна;

- 1.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, олон улсын стандартын дагуу бэлтгэгдэхгүй байх, ажил гүйлгээ, үйл явдлыг үнэн зөв бүртгэж толилуулж чадахгүй байх;

- 1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөж ажиллах.

- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийг хүлээн авч, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөж ажиллана.

2. Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжтай холбоотой асуудал

- 2.1. Илрүүлэлт: ТХН-ийн ашигладаг санхүүгийн программ нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцсэн байдлаар мэдээллийг бэлтгэн гаргадаггүй, эрх бүхий байгууллагаас гаргасан санхүүгийн программд тавигдах зарим шаардлагуудыг хангаагүй байна. Мөн санхүүгийн программаас Сангийн сайдын 2007 оны 326-р тушаалаар батлагдсан журмын дагуу тайлан гардаггүй, санхүүгийн программаас гаргаж авсан тайлан, мэдээ нь шаардлага хангахгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага”-ын 1.4-т “анхан шатны маягт, нягтлан бодох бүртгэлийн журналын маягт, санхүүгийн тайлангийн тодруулгын маягт зэрэг нь Сангийн сайдын баталсан холбогдох заавар журмын агуулгад нийцэж байх”, 1.10-т “санхүүгийн тайлангийн аудит хийхэд хялбар дөхөмтэй, мэдээллийн эх үүсвэрийг иж бүрнээр (анхан шатны баримтын мэдээлэл, дансанд бичилт хийсэн мэдээлэл) тодорхой харуулдаг байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

- 2.2. Эрсдэл: Санхүүгийн программаас гарч буй тайлан, мэдээ нь Сангийн сайдын 326-р тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн дансны заавартай нийцэхгүй байх, санхүүгийн программуудад тавигддаг шаардлагуудыг хангаагүй байх, Санхүүгийн тайлан үнэн зөв толилуулагдахгүй байх, санхүүгийн тайлангийн аудитад шаардлагатай мэдээллийг гаргаж өгч чадахгүй байх.

- 2.3. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 326-р тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайланг бэлтгэн

гаргаж чадахуйц, эрх бүхий байгууллагаас гаргасан шаардлагуудад нийцсэн санхүүгийн программыг хэрэглэх.

- 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийг хууль, тогтоомжийн дагуу мөрдөж ажиллана.

3. Балансын данстай холбоотой асуудал

- 3.1. Илрүүлэлт: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч үйл ажиллагаандаа ашиглаж байгаа үндсэн хөрөнгүүдийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, УСНББОУС-д нийцүүлэн дахин үнэлж бүртгээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр “Журам шинэчлэн батлах тухай” тогтоолын 7.1 дэх хэсэгт “Төрийн өмчийн хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар-т ирүүлж шийдвэрлүүлнэ”, УСНББОУС 23 “Арилжааны бус ажил гүйлгээний орлого”-ын 42, 44 дүгээр параграфын дагуу дахин үнэлгээний нэмэгдлийг санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор, дахин үнэлсэн хөрөнгийг УСНББОУС 17 Үндсэн хөрөнгө-ийн 14-р параграфт заасны дагуу санхүүгийн байдлын тайлан дахь тухайн хөрөнгийн дансны үнийг дахин үнэлсэн дүнгээр нэмэгдүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэн заалтуудыг тус тус мөрдөж ажиллаагүй байна.

- 3.2. Эрсдэл: Мөнгөн дүнтэй хөрөнгүүдийг бүртгэж, холбогдох элэгдлийн зардлыг бүртгээгүйн улмаас санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, оршин байх батламж мэдэгдэл зөрчигдөх, холбогдох хууль, дүрэм журам зөрчигдөх;

- 3.3. Өгсөн зөвлөмж: Элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн ашиглаж болох эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу үнэлүүлж санхүүгийн байдлын тайланд бүртгэх;

- 3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийг хууль, тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020 он	Аудитын нэр: 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/100/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	“Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн нэмэлт санхүүжилт	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансны цахим хуудсанд нийт 146 мэдээллийг оруулахаас 16 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан.	-	Албан шаардлага	Санхүүгийн ажилтан	Д.Дарьсүрэн
2	ТХН нь өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон, хууль тогтоомж, дүрэм журам, олон улсын стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй.	-	Зөвлөмж	Санхүүгийн ажилтан	Д.Дарьсүрэн
	ТХН-ийн ашигладаг санхүүгийн программ нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцсэн байдлаар мэдээллийг бэлтгэн гаргадаггүй, эрх бүхий байгууллагаас гаргасан санхүүгийн программд тавигдах зарим шаардлагуудыг хангаагүй.		Зөвлөмж	Санхүүгийн ажилтан	Д.Дарьсүрэн
4	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч үйл ажиллагаандаа ашиглаж байгаа үндсэн хөрөнгүүдийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, УСНББОУС-д нийцүүлэн дахин үнэлж бүртгээгүй.	17,892.3	Зөвлөмж	Санхүүгийн ажилтан	Д.Дарьсүрэн
ДҮН		17,892.3			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 232/АД/70080

Улаанбаатар хот

С.АТ. 2021/100/СТЗ-ТХН

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн нэмэлт санхүүжилтийн төслийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн нэмэлт санхүүжилтийн төслийн 2020 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансны цахим хуудсанд байршуулах 146 мэдээллээс 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг үнэн зөв, ил тод, хугацаанд нь байршуулж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 05 сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, ажиллахыг “Улаанбаатар хотын цэвэр агаар” төслийн нэмэлт санхүүжилтийн төслийн зохицуулагч Н.Баяртогтох, санхүүгийн ажилтан Д.Дарьсүрэнд даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР
ИНТЕР АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Ц.ЭНХЖАРГАЛ

Ч.МӨНХБАЯР

[illegible]

[illegible]